


## Хувьцааны мэдээлэл

Ханш /2025.01.22/	1,190₮
Target price	1,286₮
Тикер	MSE:KHAN
52 долоо хоног	1,008-1,207₮
Зах зээлийн үнэлгээ	2.275 их наяд ₮
Нийт хувьцааны тоо	1,912,198,000
EPS	339.9
P/B	0.92
P/E	3.61

## Хувьцаа эзэмшигчдийн бүтэц



## Ханшийн хөдөлгөөн /2024.01-2025.01/



## “Хаан Банк” ХК

Current price: 1,190₮

Target price: 1,286₮

### Компанийн тухай

“Хаан Банк” ХК нь Монгол Улсын санхүүгийн салбарт тэргүүлэгч арилжааны банк бөгөөд 1991 онд байгуулагдсан. Өдгөө улсын хэмжээнд нийт 500 гаруй салбар нэгж, 1,800 гаруй АТМ-тайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

2024 оны онцлох үйл явдлууд:

- 2 их наяд төгрөгийн зах зээлийн үнэлгээтэй анхны хувьцаат компани болсон
- Анхны ногоон бондыг гаргасан
- Alipay төлбөр тооцоо хийдэг болсон
- Digi Pay AI суурилсан төлбөр тооцооны системийг нэвтрүүлсэн
- Digi Go дижитал салбарыг байгуулсан

### Системийн 5 банкны төлөв байдал


“Хаан Банк” ХК нь нийт актив болон ашигт ажиллагаагаараа бусад банкнуудыг 2024 онд тэргүүлсэн хэвээр байна. Тодруулбал банкны нийт хөрөнгө 2024 оны жилийн эцсийн байдлаар 20 их наяд төгрөгт хүрч нийт банкны салбарын 28.4 хувийн дангаараа эзэлж байна. Нийт активын өгөөж (3.2%) болон цэвэр ашиг (638.5 тэрбум төгрөг) хамгийн өндөр үзүүлэлттэй. Эздийн өмчийн өгөөж нь 26.3%, дундажаас (24.3%) өндөр боловч Голомт Банкаас бага байна. P/B нь 0.9-тай, дундажтай ижил түвшинд байна.

	ROA	ROE	P/B	Нийт хөрөнгө*	Цэвэр ашиг*
Khan	3.2%	26.3%	0.9	20,302.7	638.5
TDB	2.0%	20.3%	0.9	15,016.0	300.1
GLMT	2.6%	32.1%	0.8	15,410.2	407.3
SBM	1.7%	17.1%	0.6	6,218.5	108.0
XAC	2.7%	25.6%	1.2	6,317.7	170.8
Дундаж	2.4%	24.3%	0.9	12,653.0	324.94


\*тэрбум ₮

## САНХҮҮГИЙН ШИНЖИЛГЭЭ


### ROA, ROE /хувиар/



### Ашгийн үзүүлэлтүүд /тэрбум ₮, хувиар/



### Үндсэн үйл ажиллагааны үзүүлэлтүүд



	2020	2021	2022	2023	2024
Зээл хадгаламжийн харьцаа	67%	95%	121%	118%	126%
Чанаргүй зээлийн хувь	7.1%	5.3%	5.7%	5.7%	4.6%

## АШИГТ АЖИЛЛАГААНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД /ROA, ROE/

2024 онд тус банкны нийт хөрөнгийн өгөөж өмнөх жилийн мөн үеэс 0.1 хувиар нэмэгдэж 3.2 хувь гарсан ба бусад системийн 5 банктай харьцуулахад хамгийн өндөр байна.

“Хаан Банк” ХК-ийн тус үзүүлэлт нь 2024 оны байдлаар 26.3 хувь байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 1.6 хувиар буурсан байна. Уг бууралтад эздийн өмчийн дүн нэмэгдсэн болон цэвэр ашгийн өсөлтийн хурд буурсан нь нөлөөлжээ.

### Хүүгийн орлогын маржин

2024 оны эцсийн байдлаар тус үзүүлэлт нь 6,5 хувь болж өмнөх оны мөн үетэй адил хэмжээнд байна. Хүүгийн орлого 2024 онд өмнөх оны мөн үеэс 24 хувиар нэмэгдсэн нь уг үзүүлэлт буураагүй шалтгаан болжээ.

### Цэвэр ашгийн маржин

Компанийн цэвэр ашиг нэмэгдсэн ч цэвэр ашгийн маржин 2024 онд 25.0 хувь байгаа буюу өмнөх оны мөн үеэс 2.2 хувиар буурчээ. Уг бууралтад харилцахад төлсөн хүүгийн зардал 230 хувиар, үнэт цаасны хүүгийн зардал 57 хувиар өссөн болон Монголбанкны заавал байлгах нөөцийн хэмжээ 2 хувиар өссөн нь гол нөлөөг үзүүлжээ.

## ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2024 оны байдлаар нийт цэвэр зээл 11 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 24 хувиар өссөн ба нийт хөрөнгийн 55 хувийг эзэлж байна. Хадгаламжийн хувьд өмнөх оны мөн үеэс 16 хувиар өсөж 8.8 их наяд төгрөг хүрсэн ба нийт өр төлбөрийн 49 хувийг, харилцахын хувьд өмнөх оны мөн үеэс 12 хувиар нэмэгдэж 5 их наяд төгрөгт хүрсэн ба нийт өр төлбөрийн 28 хувийг эзэлж байна. Чанаргүй зээлийн хувь 2024 оны байдлаар 4.6 хувь хүрсэн ба өмнөх оны мөн үеэс 1.1 хувиар буурсан нь банкны зээлийн эрсдэлийн удирдлага буурсанг харуулж байна.

### Зээл хадгаламжийн харьцаа

Олон улсын туршлагаар уг үзүүлэлт 100 хувиас өндөр байвал зээл олголтын чанар, эргэн төлөлтийн эрсдэл өндөр байх магадлалтай ба банкны эрсдэлийг нэмэгдүүлж, төлбөрийн чадвар болон тогтвортой байдлыг бууруулдаг гэж үздэг. “Хаан Банк” нь зээлийн эх үүсвэрийг төрөлжүүлж олон улсын байгууллагуудаас татдаг болохийг уг үзүүлэлт харуулж байна.

## ДҮГНЭЛТ

2024 оны эцсийн байдлаар тус компанийн P/B харьцаа 0.92, P/E харьцаа 3.61 байна. Тус үзүүлэлт бага байгаа буюу компанийн хувьцаа зах зээл дээр бодит үнэ цэнээс бага үнэлэгдэж, ашигтай ажиллаж байгаа ч ханш хямд байгааг илтгэнэ. Компани нь банкны салбарын 28 хувийг дангаараа бүрдүүлж байгаагаас гадна цэвэр ашгийн хэмжээгээр салбараа тэргүүлж байна. Мөн “Хаан Банк” ХК нь 2024 онд хамгийн өндөр дүнгээр ногдол ашиг тараасан хувьцаат компани болсон билээ.